Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2025 оны
1/11446 тоот албан бичгийн гуравдугаар хавсралт

МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН
2021 ОНООС 2025 ОНЫ ХУГАЦААНД ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮР ДҮН

2025.12.12

Улаанбаатар хот

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Төсөв\сая төг\ | | Үр дүнгийн шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | | Зорилтод түвшин | | Хэрэгжилт | Хүрсэн түвшин гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төсөвлөсөн | Гүйцэтгэл\ Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг) | | Он | Түвшин | Он | Түвшин | | |
| 103 | 5.Монгол хүний хөгжлийг хангасан ухаалаг-тогтвортой засаглал тогтож, захиргааны оновчтой бүтэц зохион байгуулалт бүхий төрийн алба төлөвшин, цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд | Нэг иргэн-нэг бүртгэл хөтөлбөр | 42.563.0 | 20.760.6 Улсын төсөв | “Нэг иргэн-Нэг бүртгэл” арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх. Улсын бүртгэлийн цахим үйлчилгээг өргөжүүлнэ. | 2024 он | Хэрэг-жилт 100 хувьд хүрсэн байна. | 2025 он | - | Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээг цахим хэлбэрээр бүртгэх, бүртгүүлэх боломжийг бүрдүүлэх, мэдээллийн чанарыг сайжруулах, цахим системийн чанарыг дээшлүүлж төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй хүргэх зорилгоор Төрийн үйлчилгээний нэгдсэн портал /E-Mongolia/, /E-business/-аар давхардсан тоогоор нийт 151 лавлагаа, үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэн үзүүлж байгаа бөгөөд 2025.11.11 өдрийн байдлаар E-Mongolia системээр иргэний бүртгэлийн чиглэлээр 210,162 үйлчилгээ, 17,008,884 лавлагаа, эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр 126 үйлчилгээ, 4,363,082 лавлагаа, хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр | 100 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | бүрэн шилжиж, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтын ажиллагаа бүх хүрээнд өргөжин, хүний эрхийг хангасан, шударга ёсны тогтолцоо төлөвшсөн, авлигагүй улс болно. | | | | | | | | | 215,714 лавлагаа, E-Business системээр 162,087 үйлчилгээ, 39,363 лавлагаа, эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр 11 үйлчилгээ тус тус үзүүлсэн байна. | |
| | | Хэсгийн дундаж | | | | | | | | | 100 |
| 104 | | Улсын бүртгэлийн ерөнхий газар, орон нутаг дахь улсын бүртгэлийн хэлтсийн архив, үйлчилгээний байр, тохижилт, техник хэрэгсэл, аюулгүй ажиллагаа, хадгалалт, хамгаалалт: | 22.816.0 | 22.800.0 Гадаад зээл, тусламж /БНСУ-ын буцалтгүй тусламж/ | | 2021 он | Төслийн ажлын явц 80 хувь. | 2022 он | Төслийн ажлын явц 100 хувь. | Бүртгэлийн байгууллагын хэмжээнд ашиглаж байгаа техник, тоног төхөөрөмж, програм хангамжийг шинэчлэх, сайжруулах"-ын хүрээнд олон ажил хийгдэж байгаа бөгөөд БНСУ-ыг олон улсын хамтын ажиллагааны байгууллага /КОЙКА/-аас буцалтгүй тусламжаар хэрэгжүүлж буй "Улсын бүртгэлийн системийн үйл ажиллагааг дэмжих төсөл"-ийн хүрээнд Техник тоног төхөөрөмжийн шинэчлэл, өгөгдлийн сангийн удирдлагын систем, хяналтын системүүдийг албан ёсны эрхтэйгээр нийлүүлж, ашиглалтад оруулан ажиллав. | 100 |
| | | | 55,168.5 | 16,000.00 Улсын төсөв | 2.Улсын бүртгэлийн ерөнхий газрын Архив, үйлчилгээний цогцолбор төвийн барилга ашиглалтад орсон байна. | 2020 он | Хэрэг-жилт 70 хувьд хүрсэн байна. | 2021 он | Хэрэг-жилт 100 хувьд хүрсэн байна. | УБЕГ-ын Архив, үйлчилгээний цогцолбор төвийн барилгыг 2021.03.01-ний өдөр Улсын комисс хүлээн авч, барилгын хаягжуулалт, тохижилтын ажлууд бүрэн хийгдсэн. Мөн тус газрын Мэдээллийн технологийн төвийн байранд нууцлал, аюулгүй байдал, стандарт шаардлагад нийцсэн иргэний үнэмлэх, гадаад паспортын бичилтийн хэвлэх үйлдвэр болон улсын бүртгэлийн цахим мэдээллийн сангийн сервер, техник, тоног төхөөрөмжийг суурилуулж, их засварын ажлыг | 100 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | хийхээр төлөвлөн их засвар тохижилтын ажлыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021.06.25-ны өдрөөс 08 дугаар сарын 01-ний хугацаанд хэрэгжүүлж, УБЕГ-ын Мэдээлэл технологийн төвийн байрыг ашиглалтад оруулсан. | |
| | | | | 8,444.00 Улсын төсөв | 3.Гадаад паспортын тоног төхөөрөмж, програм хангамжийг сайжруулсан байна. | - | - | 2022 он | Хэрэг-жилт 100 хувьд хүрсэн байна. | Үндэсний энгийн гадаад паспортын бичилтийн үйлдвэрийн байрыг олон улсын стандартыг хангасан байдлаар засварлан тоног төхөөрөмжийг бүрэн суурилуулж 2022.10.01-ний өдрөөс ашиглалтад оруулсан.<br>Засгийн газрын 2023.02.08-ны өдрийн 69 дүгээр тогтоолоор үндэсний энгийн гадаад паспортын бэлдэц үйлдвэрлэх, бичилт хийх "Төрийн үнэт цаас хэвлэл" төрийн өмч давамгайлсан хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрэм батлагдсан. Төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээр Улсын бүртгэлийн ерөнхий газар нь 51 хувийн хувьцаа эзэмшигчээр, “Мигасон” ХХК нь 49 хувийн хувийн хувьцаа эзэмшигчээр хуулийн этгээдийн улсын бүртгэлд 2023.04.11-ны өдөр "Төрийн үнэт цаас хэвлэл" ТӨДХХК бүртгэгдсэн. “Мигасон” ХХК-тай 2023 онд байгуулсан “Гадаад паспортын бэлдэц нийцүүлэх гэрээ”, “Смарт карт” ХХК-тай байгуулсан “Монгол Улсын иргэний үнэмлэхийн бэлдэц нийлүүлэх гэрээ”-ний | 100 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | дагуу бэлдцийг хүлээн авч ажиллаж байна. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024.05.16-ний өдрийн 234 дүгээр тогтоолоор УБЕГ-ын хөрөнгөд бүртгэлтэй 43 нэр төрлийн 16,115.1 сая төгрөгийн үнэтэй хөрөнгийг "Төрийн үнэт цаас хэвлэл" ТӨДХХК-ийн төрийн мэдлийн 51 хувьд тооцон хувь нийлүүлсэн хөрөнгө /дүрмийн сан/-д шилжүүлсэн. Тогтоолын дагуу 2024.10.26-ны өдөр үйлдвэрийг тоног төхөөрөмж, программ хангамж, улсын бүртгэлийн сүлжээг тусгай зориулалтын байранд нүүлгэн шилжүүлсэн. | |
| | | | | 3,700.00 Улсын төсөв | 4.Иргэний үнэмлэх хэвлэх тоног төхөөрөмжийг сайжруулсан байна | - | - | 2022 он | Хэрэг-жилт 100 хувьд хүрсэн байна. | "Монгол Улсын иргэний үнэмлэх хэвлэх үйлдвэрийн тоног төхөөрөмжийг шинэчлэх" ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, худалдан авах ажиллагааг зохион байгуулж, 2022.02.14-ний өдөр гэрээг байгуулан системийн программ хангамж, лицензийн хамт 2022 оны 07 дугаар сард хүлээн авч, 2022.08.12-ны өдрөөс эхлэн шинэ тоног төхөөрөмжөөр иргэний үнэмлэх хэвлэх үйл ажиллагааг эхлүүлсэн. | 100 |
| | | | | 4,519.50 Улсын төсөв | 5.Хэнтий аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн барилга ашиглалтад оруулсан байна | 2022 | 80 хувь | 2023 он | 100 хувь | Хууль зүй, дотоод хэргийн сайдын баталсан 2023 оны худалдан авах ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан 2,519,9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Хэнтий аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн барилгын ажлын гүйцэтгэгчээр "Мандалт констракшн" ХХК ажиллаж, нийт | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | 938 м/кв зоорийн давхар бүхий дөрвөн давхар барилгыг улсын комисс 2023.12.01-ний өдөр хүлээн авч, улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлж байна. | |
| | | | | 5,069.00 Улсын төсөв | 6.Ховд аймгийн улсын бүртгэлийн хэлтэс, архивын тасгийн барилга ашиглалтад оруулсан байна | 2022 | 80 хувь | 2023 он | 100 хувь | Ховд аймгийн улсын бүртгэлийн хэлтэс, архивын тасгийн барилга угсралтын ажлын гүйцэтгэлийг хянан 2023.02.10-ны өдөр ХЗДХЯ-нд 26,0 хувийн гүйцэтгэлд 1.333,9 сая төгрөгийн санхүүжилтийн хүсэлт хүргүүлж, барилгын ажлын гүйцэтгэгчээр ГЦЦЭ ХХК ажиллаж, барилгыг улсын комисс 2023.11.20-ны өдөр хүлээн авч, улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлж байна. | 100 |
| | | | | 868.00 Улсын төсөв | 7.Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн барилгад их засвар хийгдсэн байна | | | 2024 он | Хэрэг-жилт 100 хувьд хүрсэн байна. | Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн байрны их засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2024 оны А/03 тоот тушаалаар байгуулагдан "Өгөөмөр уул" ХХК-тай ХЗДХЯ/20240101023, 24 тоот гэрээ байгуулсан бөгөөд 2024.08.25-ны өдрийн байдлаар гэрээний гүйцэтгэл 100 хувь хангагдсан. | 100 |
| | | | | 500.00 Улсын төсөв | 8.Хөвсгөл аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн барилгад их засвар хийгдсэн байна | | | 2023 он | Хэрэг-жилт 100 хувьд хүрсэн байна. | Хөвсгөл аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн байрны их засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын зөвшөөрсөн, Хөвсгөл аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн даргын 2023 оны 06 дугаар сард "Өгөөмөр уул" ХХК-тай УБЕГ/2023/12009, 2023/20 тоот | 100 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | гэрээ байгуулсан бөгөөд 2023 оны 8 дугаар сард гэрээний гүйцэтгэл 100 хувь хангагдсан. | |
| | | | | 2,500.00 Улсын төсөв | 9.Сонгинохайрхан дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн барилга ашиглалтад оруулсан байна | 2024 он | - | 2026 он | - | Сонгинохайрхан дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн барилга угсралтын ажлыг барих гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо байгууллагын даргын 2024.03.14-ний өдрийн А/39 тоот тушаалаар байгуулагдсан. BBSMO ХХК-тай 2024.09.06-ны өдөр 2024/64 тоот гэрээг байгуулан хамтран ажиллан, Барилгын хөгжлийн төвийн барилга байгууламжийн дүгнэлт 2024.11.18-ны өдөр баталгаажиж, нийт төсөвт өртөг 6,4 тэрбум төгрөгөөр баталсан. Барилга угсралтын ажлыг барих гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн нээлтийг хуулийн хугацаагаар 2024.12.13-ны өдөр нээж, шалгаруулан “Мандалт констракшн” ХХК-тай хэлэлцээр хийж зөвхөн барилга угсралтын ажлыг хийлгэн 2024 онд тус арга хэмжээний төсөвт өртөг 2,534,800.000 төгрөг батлагдсан төсвөөр санхүүжүүлэхийг тохиролцон, 2024.12.26-нд гэрээ байгуулж, ХЗДХЯ баталгаажуулсан. Гэвч улсын хөрөнгө оруулалтын төсөв буцааж татагдсан тул барилгын ажил эхлээгүй. | 30 |
| | | | | - | 10. Бүртгэлийн байгууллагын архивын | 2025 он | - | 2026 он | - | Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны “Хөтөлбөр батлах тухай” А/206, байгууллагын даргын 2024 оны А/180 дугаар “Төрийн албан | 30 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | цогцолбор төв байгуулах | | | | хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр батлах тухай", 2025 оны А/96, А/97 дугаар "Ажлын хэсэг байгуулах тухай" тушаалын хэрэгжилтийг хангах арга хэмжээний хүрээнд Улсын бүртгэлийн ерөнхий газрын архивын зориулалттай барилга байгууламж болон албан хаагчдын орон сууцны барилга, угсралтын ажлыг гүйцэтгэх гэрээг 2025.05.30-ны өдөр "Буянт шарга констракшн"-тай байгуулан, барилгын шав тавих ёслолыг 2025.06.05-ны өдөр зохион байгуулсан. Архивын зориулалттай барилга нь 1,500 м.кв талбайтай, хоёр давхар (зоорины давхартай) байхаар төлөвлөгдөж, барилгын нийт өртөг 6 тэрбум төгрөгийг гүйцэтгэгч "Буянт Шарга Констракшн" ХХК 100 хувь өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэн барьж гүйцэтгэн, 2026 оны 4 дүгээр улиралд хүлээлгэн өгөхөөр төлөвлөн ажиллаж байна.<br>Барилга байгууламжийг барихад шаардлагатай архитектур төлөвлөлтийн даалгавар, цахилгааны техникийн нөхцөл, цэвэр ус, дулаан, бохирын техникийн нөхцөл, аэродромын хил хязгаарлах гадаргуугийн тооцоолуурын дүгнэлт, барилгын эскиз зураг, мэдээлэл холбооны сүлжээний техникийн нөхцөлийг холбогдох байгууллагуудаас тус тус гаргуулсан. | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 13,567.00 Улсын төсөв | 10.Техник хэрэгсэл аюулгүй ажиллагааны программ хангамж сайжирсан байна | 2021 он | - | 2025 он | - | Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2021.12.17-ны өдөр УИХ-ын нэгдсэн чуулганаар баталж 2022.05.01-ны өдрөөс мөрдөж эхэлсэн. Улсын бүртгэлийн ерөнхий газраас Монгол Улсын 16 ба түүнээс дээш насны 2,2 сая иргэддээ тоон гарын үсгийг 21 аймаг, 9 дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтэс, Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвүүдээр олгож эхэлсэн бөгөөд иргэний үнэмлэхийн санах ой буюу чипэнд, улсын бүртгэлийн үйлчилгээний цахим машин /КИОСК/-аар, гар утасны аппликэйшаар олгож байна.<br>"Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангийн сервер, сүлжээ, мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангах" худалдан авалт хийгдсэн. "Смарт карт" ХХК-тай 2025.06.02-ны өдөр Н2025/27 дугаартай 55,000 (мян.төг) дүнтэй гэрээний байгуулсан. Тус ажлын хүрээнд иргэний үнэмлэх хэвлэх үйлдвэрийн тоног төхөөрөмжид засвар үйлчилгээг хийж гүйцэтгэсэн.<br>"Тог баригчийн батарей" худалдан авсан. "Жи Си Эс Эм" ХХК-тай 2025.06.06-ны өдөр 2025/28 дугаартай 59,500.0 (мян.төг) гэрээ байгуулан, гэрээний дагуу 80 ширхэг шинэ батарейг хугацаанд нь нийлүүлж, хүлээлгэн өгсөн.<br>Серверийн хөргөлт агааржуулалт болон дизель генераторын үзлэг үйлчилгээ худалдан авалт хийгдсэн. "И ти | 100 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | креатив" ХХК-тай 2025.06.02-ны өдөр 2025/26 дугаартай 19,440.0 (мян.төг) дүнтэй гэрээ байгуулан, эрчим хүчний аюулгүй байдал болон тоног төхөөрөмжийн хэвийн, найдвартай ажиллагааг хангах зорилгоор гэмтэлтэй 80 ширхэг тог баригчийн батарейг шинээр худалдан авч суурилуулсан. Мөн төвийн эрчим хүчний тэжээл тасарсан нөхцөлд Улсын бүртгэлийн ерөнхий газрын хоёрдугаар байрыг тасралтгүй цахилгаан хангамжаар хангахын тулд автомат горимоор ажилладаг CUMMINS C275 загварын, 250 kVA хүчин чадалтай дизель генераторт улирал бүр серверийн өрөө болон хэвлэх үйлдвэрийн хэрглтийн төхөөрөмжид тогтмол үзлэг, үйлчилгээ хийж, шаардлагатай сервист ажлуудыг хугацаанд нь гүйцэтгэж байна.<br>Аймаг, дүүргийг бүртгэлийн нэгдсэн хяналтад холбох ажил" худалдан авалт хийгдсэн. "Лимитлэсс элэвэйт" ХХК-тай 2025.06.02-ны өдөр 2025/25 дугаартай 19,460.0 (мян.төг) дүнтэй гэрээ хийгдсэн. 2025 оны 09 дүгээр сард Хөвсгөл аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчдын 39 ширхэг, Баянзүрх дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн 78 ширхэг компьютерт тус тус үзлэг, оношилгоо, засвар үйлчилгээ, Domain Control системийн тохиргоо болон холболтыг хийж | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | сүлжээний аюулгүй байдал, хяналт, нэгдсэн удирдлагын түвшин нэг шат ахиж, мэдээллийн найдвартай байдал сайжирсан. Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2025 оны "Худалдан авах ажиллагааны төлөвлөө"-нд тусгагдаагүй нууцын гэрээ байгуулан "17 киоск машины программын хөгжүүлэлт" шууд худалдан авалт хийгдсэн. "Нью компас" ХХК-тай 2025.03.25-ний өдрийн 2025/05 дугаартай, 10,000.0 (мян.төг) дүнтэй гэрээ хийгдсэн. Тус ажлын хүрээнд 2025.10.17-ны өдөр Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс болон 27, 29, 30, 39 дүгээр хороодод байршуулсан байсан ДӨТ машиныг, 2025.10.13-14-ний өдрүүдэд Чингэлтэй дүүргийн 1, 2, 7, 8, 11, 13, 21, 23 дугаар хороодод байршуулсан Улсын бүртгэлийн цахим (Киоск) машинд үйлдлийн систем суулгаж, дотоод сүлжээнд холбон хэвийн үйл ажиллагаанд оруулсан. | |
| Хэсгийн дундаж | | | | | | | | | | | 87,3 |
| Хэрэгжилтийн хувь | | | | | | | | | | | 94 |